

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАГЦ ДҮРМИЙН
ХАМААРАЛ**

<i>Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн заалтууд</i>	<i>ИНБД</i>
<p><i>8.4. Иргэний нисэхийн ерөнхий газар нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</i> <i>8.4.1. Чикагогийн конвенцийн Хавсралтуудад нийцсэн аюулгүй ажиллагааны стандартыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах буюу бүртгүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих</i></p>	<p>Ерөнхий журам тогтоосон -3 /ИНД-11, 12, 13/ Агаарын хөлөг- 5 /ИНД-21, 26, 39, 43, 47/ Ажилтны үнэмлэхжүүлэлт- 6 /ИНД-61, 63, 65, 66, 67, 183/ Агаарын зай- 4 /ИНД-71, 73, 75, 77/ Нислэгийн үйл ажиллагаа- 8 /ИНД-91, 92, 95, 101, 103, 104, 105, 106/ Агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх болон нислэгийн бусад үйл ажиллагаа-7 /ИНД-115, 119, 121, 129, 133, 135, 137/ Аэродром- 2 /ИНД-139, 157/ Агаарын навигацын үйлчилгээний байгууллагуудыг гэрчилгээжүүлэх- 6 /ИНД-171, 172, 173, 174, 175, 138/ Иргэний нисэхийн бусад байгууллагуудыг гэрчилгээжүүлэх- 7 /ИНД-140, 141, 144, 145, 148, 149, 337/ Бусад- 12 /ИНД-108, 109, 131, 191, 203, 301, 303, 307, 313, 321, 329, 331/ /60 дүрэм/</p>
<p><i>11.2. Иргэний нисэхийн багц дүрмээр дараахь үйл ажиллагааг зохицуулна:</i> <i>11.2.1. Монгол Улсад агаарын хөлгийг бүртгэх</i></p> <p><i>11.2.2. нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох</i></p> <p><i>11.2.5. Монгол Улсын хилээр агаарын хөлөг нэвтрэх, аэродромд буух, хөөрөх, түүнчлэн Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх, нислэгийн хөдөлгөөн удирдах</i></p>	<p>ИНД-47 /Агаарын хөлгийн бүртгэл, таних тэмдэг/ ИНД- 21 /Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги, гэрчилгээжүүлэлт/ ИНД-71 /Агаарын зайг тогтоох/ ИНД-73 /Тусгай зориулалтаар ашиглах агаарын зай/ ИНД-75 /Агаарын навигацын үйлчилгээний зайчлалын стандарт/</p>
<p><i>13.1. Иргэн, аж ахуйн нэгж иргэний нисэхийн дараахь үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл авна:</i> <i>13.1.1. агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх</i> <i>13.1.2. аэродром, нисэх буудлын үйлчилгээ эрхлэх</i> <i>13.1.3. агаарын хөлгийн засвар, үйлчилгээ хийх</i></p>	<p>ИНД-119 /Агаарын тээвэрлэгч-Гэрчилгээжүүлэлт/ ИНД-139 /Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт/ ИНД-145- Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага-гэрчилгээжүүлэлт</p>

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан тусгай зөвшөөрлийг Иргэний нисэхийн ерөнхий газар Иргэний нисэхийн багц дүрмийн дагуу олгоно.	
15-р зүйл. <i>Иргэний агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар</i> 15.2. Гадаад улсад үйлдвэрлэгдсэн агаарын хөлөг /маяг/-ийг Иргэний нисэхийн ерөнхий газраас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд уг агаарын хөлгийг Монгол Улсад иргэний нислэг үйлдэх зорилгоор ашиглана.	ИНД-21 –Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги, гэрчилгээжүүлэлт Б Бүлэг. Маягийн гэрчилгээ, маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ
16-р зүйл. <i>Иргэний агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах</i> 16.1, 16.2, 16.3 16.4. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг даатгуулна.	ИНД-47- Агаарын хөлгийн бүртгэл, таних тэмдэг ИНД-303- Агаарын тээвэрлэгчийн даатгал В Бүлэг. Агаарын хөлгийн даатгал
17-р зүйл. <i>Иргэний агаарын хөлгийн баг</i> 17.1, 17.2, 17.3, 17.4, 17.5	ИНД-91- Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм А Бүлэг. Ерөнхий зүйл Б Бүлэг. Үйл ажиллагааны шаардлага
18-р зүйл. <i>Иргэний агаарын хөлгийн даргын бүрэн эрх</i>	ИНД-91- Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм В Бүлэг. Нислэгийн ерөнхий дүрэм
19-р зүйл. <i>Аэродром байгуулах</i> 20-р зүйл. <i>Аэродром орчмын аюулгүйн бүс</i> 21-р зүйл. <i>Аэродромын дохио тэмдэг</i> 22-р зүйл. <i>Барилга байгууламж дээрх дохио тэмдэг</i>	ИНД-77- Нам өндрийн нислэгт саад учруулах барилга байгууламж болон үйл ажиллагаа ИНД-139- Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт ИНД-157- Аэродром байгуулах, өөрчлөх, ашиглалтаас хасах
23-р зүйл. <i>Нислэг үйлдэх</i>	ИНД-91- Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм
24-р зүйл. Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт 24.2. Монгол Улсын агаарын зайд үйлдэх нислэгийн хоорондын аюулгүйн зай, агаарын зам, түүний өргөн, өндөр нь олон улсын стандартад нийцсэн байна.	ИНД-75 Агаарын навигацын үйлчилгээний зайчлалын стандарт
34-р зүйл. <i>Зорчигч, ачаа, тээш, шуудан тээвэрлэх</i>	ИНД-329 Тээвэрлэлтийн гэрээ ИНД-331 Зорчигчдын бүртгэл
35-р зүйл. <i>Агаарын хөлгөөр аюултай ачаа тээвэрлэх</i>	ИНД-92 Аюултай ачаа тээвэрлэх
37-р зүйл. <i>Иргэний агаарын хөлгийн багийн гишүүдийн даатгал</i>	ИНД-303- Агаарын тээвэрлэгчийн даатгал Д Бүлэг. Агаарын хөлгийн багийн гишүүдийн

	даатгал
<i>38-р зүйл. Тээвэрлэгчийн хариуцлагын даатгал</i>	ИНД-303- Агаарын тээвэрлэгчийн даатгал Г Бүлэг. Тээвэрлэгчийн хариуцлагын даатгал
39.1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь нисэхийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөртэй байна.	Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр /ЗГ-ын тогтоолоор батлагдсан/
39 ¹ .1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн ажилтанд мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ олгоно. Үнэмлэх, гэрчилгээ олгох журмыг Иргэний нисэхийн багц дүрмээр тогтооно.	ИНД-61 /Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл/ ИНД-63 /Нисгэгчээс бусад нисэх багийн гишүүдийн үнэмлэх, зэрэглэл/ ИНД-65 /Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл/ ИНД-66 /Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл/ ИНД-67 /Иргэний нисэхийн эрүүл мэндийн стандарт, гэрчилгээ/
39 ² .1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсад бүртгэлтэй иргэний агаарын хөлөгт Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно...	ИНД-21 /Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги, гэрчилгээжүүлэлт/
39 ³ .1. Энэ хуулийн 13.1.1-д заасан, агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага энэ хууль болон холбогдох дүрэм, журмын шаардлагыг хангасан тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газар Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгоно.	ИНД-119 /Агаарын тээвэрлэгч-гэрчилгээжүүлэлт/
40.1. Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах, агаарын хөлгийн багийн гишүүд, зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор агаарын хөлгийн багийн гишүүн, зорчигчийн бие болон тээшинд агаарын тээвэрлэгч буюу эрх бүхий байгууллага иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу үзлэг хийнэ.	ИНД-140 /Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх/
<i>Есдүгээр бүлэг. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах</i>	ИНД-203 Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах